

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

АУДИТЫН КОД: ГСА-2025/06-6-ШТА-НА

Энэхүү аудитын тайлантай холбоотой
нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: www.audit.mn

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудитор:

Б.Сарантуяа, Утас: 70543179

Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр,

Утас: 70543179

Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Дарханбат, Утас: 70543179

Цахим хаяг: darkhanbatb@audit.gov.mn

Аудитор: Г.Ариунцэцэг, Утас: 70543179

Цахим хаяг: ariuntsetsegg@audit.gov.mn

Тайланг бэлтгэсэн:

Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор
Б.Сарантуяа

Аудитын менежер
Г.Наранбаяр

Ахлах аудитор
Б.Дарханбат

Аудитор
Г.Ариунцэцэг

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
70543179 дугаарын утсаар
харилцана уу.

ХАЯГ:

Сүмбэр сум 3-р баг,
Нутгийн удирдлагын
ордон, 213 тоот

2025 оны 04 дүгээр сар

Бүлэг-1

Говьсүмбэр аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг хууль, журамд нийцүүлэн төлөвлөсөн боловч баталсан төсөл, арга хэмжээний зориулалтыг өөрчлөн тоног төхөөрөмж ангиллаас тавилга, эд хогшил худалдан авсан байна. 9

1. А.1. Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд Говьсүмбэр аймагт хэрэгжихээр батлагдсан 22 төсөл, арга хэмжээний 16 буюу 72.7 хувь нь улсын жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй нийцсэн байна.9
2. А.2. Говьсүмбэр аймгийн ТЕЗ-ийн саналаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээг цахим системээр аргачлалын дагуу үнэлж эрэмбэлэн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцсон байна.10
3. А.3. Аймгийн ТЕЗ-ийн саналд үндэслэж шинээр хэрэгжихээр батлагдсан 8 төсөл, арга хэмжээ төлөвлөлтийн шаардлага хангасан.10
4. А.4. Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд Политехник коллежийн тоног төхөөрөмж нэр, зориулалттай батлагдсан боловч төслөөс тавилга эд хогшил, хангамжийн материал худалдан авч зориулалтыг нь өөрчилсөн байна.11

Политехник коллежийн тоног төхөөрөмж нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулаагүй байна. 12

5. Б.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах, эрх шилжүүлэх, худалдан авах ажиллагааны журмыг сонгох үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.12
6. Б.2 Политехник коллежийн тоног төхөөрөмж худалдан авах тендер шалгаруулалтын баримт бичгийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн боловсруулаагүй байна.13
7. Б.3 Үнэлгээний хороо тендер шалгаруулалтын баримт бичгийг бодитоор үнэлээгүйгээс шаардлага хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.14

Зарим ажлын гүйцэтгэлийг бодитоор баталгаажуулаагүй, он дамжин хэрэгжиж буй 3 төсөл хугацаандаа хэрэгжээгүй, ашиглалтад хүлээн авсан Шивээговь сумын цэцэрлэгийн барилгыг хөрөнгийн бүртгэлд бүртгээгүй, Политехник коллежид нийлүүлсэн сургалтын тоног төхөөрөмж ашиглалтын шаардлага хангахгүй байна. 15

8. В.1 Зарим ажлын гүйцэтгэлийг бодитоор баталгаажуулаагүй байна.15
9. В.2 Он дамжин хэрэгжиж буй 3 төсөл, арга хэмжээ гэрээний хугацаандаа хэрэгжээгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна.16
10. В.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн зарим тоног төхөөрөмж техникийн тодорхойлолтод нийцээгүй, захиалагч, ашиглагч байгууллага, хүлээн авах комисс

шаардлага хангаагүй тоног төхөөрөмжийг хүлээн авсан байна.
.....18

11. В.4 Политехник коллежид нийлүүлсэн тоног төхөөрөмжийн
дүнг 4.6 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн, универсал трактор
болон зарим тоног төхөөрөмжүүд ашиглалтын шаардлага
хангахгүй байгаагаас зориулалтын дагуу ашиглаагүй байна.19

Дүгнэлт

Зөвлөмж

Шалгагдагч байгууллагын санал тайлбар

Тайлангийн хавсралтууд

ТОВЧИЛСОН ҮГС

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ГА	Гүйцэтгэлийн аудит
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ГСА	Говьсүмбэр аймаг
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗДҮАХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨАГ	Орон нутгийн өмчийн газар
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ҮАХ	Үйл ажиллагааны хөтөлбөр
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс
ХАА	Худалдан авах ажиллагаа
ЭЗНХҮЧ	Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө, Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх;
- Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авалтыг хууль журмын дагуу зохион байгуулсан эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Авто замын тухай хууль
- УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”
- Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- “Алсын хараа” 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам” болон холбогдох бусад аргачлал

**Аудитын хамарсан
хүрээ:**

- Батлагдсан зураг төсөв, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ, бусад холбогдох эрхзүйн актууд
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт

Аудитын арга зүй:

Аудитад Говьсүмбэр аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаас 2024 онд хэрэгжүүлэхээр шилжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа, санхүүжилт, хэрэгжилт болон аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагууд болох аймгийн ЗДТГ, ГХБХБГ, ОНӨГ, захиалагч байгууллагууд, хяналт хэрэгжүүлсэн байгууллагуул, холбогдох бусад гүйцэтгэгч аж ахуй нэгжийг хамруулан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, ХАА-ны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагуудаас хяналт хийсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд аудитыг гүйцэтгэлээ.

Аудитыг АДБОУС 4000-4200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

**Аудит хийх багийн
бүрэлдэхүүн,
хугацаа:**

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дарханбат, аудитор Г.Ариунцэцэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

Аудитын гүйцэтгэлийн үе шатыг 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрөөс эхлүүлж, тайланг шалгагдагч байгууллага болон холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр хүргүүлээ.

Хүндрэл бэрхшээл:

**ҮНДСЭН
МЭДЭЭЛЭЛ**

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар Говьсүмбэр аймагт хэрэгжихээр нэр зааж баталсан 102,458.4 сая төгрөгийн 15, Говьсүмбэр-Дундговь аймагт хэрэгжих 3,000.0 сая төгрөгийн 2, Говьсүмбэр-Дундговь-Дорноговь аймагт хэрэгжих 1,000.0 сая төгрөгийн 1 нийт 106,458.4 сая төгрөгийн 18 төсөл, арга хэмжээ батлагджээ.

Мөн Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд нэр зааж батлагдаагүй боловч Төсвийн Ерөнхийлөн захирагчийн багцаас 11,911.2 мянган төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ Говьсүмбэр аймагт хэрэгжсэн байна.

2024 онд батлагдсан төсөл, арга хэмжээний тоо, төсөвт өртгийн хэмжээг өмнөх онуудтой харьцуулбал:

Он	(сая төгрөгөөр)					
	Шинэ		Шилжих		Нийт	
	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг
2024	15	89,116.5	7	29,253.1	22	118,369.6
2023	0	-	10	46,357.7	10	46,357.7
2022	4	11,856	6	28,662	10	40,518
2021	2	3,700	7	19,414	9	23,114

Хүснэгтээс харахад: Говьсүмбэр аймагт 2024 онд 118,369.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 22 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан байна. Үүнээс 89,116.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 15 төсөл, арга хэмжээ шинээр хэрэгжсэн бол 29,253.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 төсөл, арга хэмжээ шилжих хөрөнгө оруулалтаар батлагджээ.

Тайлант хугацаанд ТЕЗ-ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 5,704.8 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулж гэрээний хэмнэлт 63.8 сая төгрөг үүссэн байна.

Зургийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Шивээговь сум, 1 дүгээр баг/	18
Зураг 2	4.2 сая төгрөгийн хурлын заалны микрофон ашиглалтгүй.	18
Зураг 3	4.2 сая төгрөгийн 48 порттой сүлжээ салаалагч ашиглалтгүй.	18
Зураг 4	268.5 сая төгрөгийн универсал трактор	18
Зураг 5	1.2 сая төгрөгийн хөргүүр	18

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт Говьсүмбэр аймагт хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт	9
Хүснэгт 2	ТЕЗ-ийн хүргүүлсэн санал болон батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалт	10
Хүснэгт 3	ТЕЗ-ийн саналд үндэслэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалт	10
Хүснэгт 4	Политехник коллежийн тоног төхөөрөмж төслөөр худалдан авсан тавилга, эд хогшлын жагсаалт	11
Хүснэгт 5	Говьсүмбэр, Дундговь аймагт хэрэгжихээр батлагдсан ТАХ-ний жагсаалт	11
Хүснэгт 6	Худалдан авах ажиллагааны судалгаа	12
Хүснэгт 7	Багц №1, №2, №3-н техникийн тодорхойлолтод зайлиггүй шаардлагатай үзүүлэлт, хүчин чадлыг тусгаагүй тоног төхөөрөмжийн жагсаалт	13
Хүснэгт 8	Санхүүжилтийн судалгаа	15

БҮЛЭГ 1

Говьсүмбэр аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг хууль, журамд нийцүүлэн төлөвлөсөн байна.

А.1. Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд Говьсүмбэр аймагт хэрэгжихээр батлагдсан 22 төсөл, арга хэмжээний 16 буюу 72.7 хувь нь улсын жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй нийцсэн байна.

Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1¹-т заасны дагуу шаардлага хангасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хамрагдах хуулийн зохицуулалттай байна. Улсын Их хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т дараах төсөл, арга хэмжээг Говьсүмбэр аймагт хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт Говьсүмбэр аймагт хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт

Хүснэгт №1

№	Төлөвлөгөөний №	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр	Хариуцагч
1	2-7	200 сургууль, 273 цэцэрлэг барих төсөл	2021-2024	Улсын төсөв	БШУЯ
2	4-69	Эрчим хүчний төсөл-2 /Архангай, Булган, Говьсүмбэр, Дорноговь, Завхан, Нийслэл/	2017-2022	ДБ-ны хөнгөлөлттэй зээл	ЭХЯ
3	4-70	Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл /Говьсүмбэр/	2020-2023	/ХБНГУ-ын хөнгөлөлттэй зээл/	ЭХЯ
4	8-122	10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл /Баян-Өлгий, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ/	2019-2022	/БНСУ-ын хөнгөлөлттэй зээл/	ЭХЯ
5	8-123	Аймгийн төвүүдийн бохир ус цэвэрлэх байгууламжийн шинэчлэл /Баян-Өлгий, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ/	2021-2022	/БНПУ-ын хөнгөлөлттэй зээл/	БХБЯ
6	8-129	Чойр дэд станцын өргөтгөл, шинэчлэл /Концессын эргэн төлөлт/	2019-2022	Улсын төсөв	ЭХЯ
7	8-130	Чойр-Сайншандын 230 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төсөл	2021-2025	/ЕСБХБ-ны хөнгөлөлттэй зээл	ЭХЯ

(Эх сурвалж: Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр)

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар 22 төсөл, арга хэмжээ батлагдсан бөгөөд холбогдох бодлогын баримт бичгүүдтэй уялдуулсан эсэхийг тулган баталгаажуулахад дараах байдалтай байна. Үүнд:

1. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт – дээрх 22 төсөл, арга хэмжээнээс 10 төсөл арга хэмжээ нь нийцсэн бол 12 төсөл, арга хэмжээ нь нийцээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуульд заасан 30.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй байх шалгуурыг хангаагүйтэй холбоотой байна. (Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд Говьсүмбэр аймагт хэрэгжихээр батлагдсан төсөл, арга хэмжээний хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй нийцсэн байдлыг хавсралт №1-ээс үзнэ үү.)

¹ 28.1. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангахад чиглэгдсэн, нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хамруулна.

2. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө- /Улсын Их хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан/ - дээрх 22 төсөл, арга хэмжээнээс уг төлөвлөгөөтэй 10 нь нийцсэн бол 6 төсөл, арга хэмжээ нь агуулгын хувьд нийцсэн, 6 төсөл арга хэмжээ огт нийцээгүй байна. (Дэлгэрэнгүйг хавсралт №1-ээс үзнэ үү.)

А.2. Говьсүмбэр аймгийн ТЕЗ-ийн саналаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээг цахим системээр аргачлалын дагуу үнэлж эрэмбэлэн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцсон байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны 04 сарын 25-ны өдрийн А/442, 07 сарын 26-ны өдрийн А/797 тоот албан бичгээр Говьсүмбэр аймагт 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг бэлтгэн Сангийн яам болон Төсвийн Ерөнхийлөн захирагчдад хүргүүлсэн байна. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг pimis.publicinvestment.gov.mn цахим системээр үнэлэн, эрэмбэлж, эдийн засгийн үр ашгийг аргачлалын дагуу тооцжээ.

ТЕЗ-ийн хүргүүлсэн санал болон батлагдсан
төсөл, арга хэмжээний жагсаалт

Хүснэгт №2

(сая төгрөгөөр)

№	Санал хүргүүлсэн ТЕЗ	2024 онд шинээр хэрэгжүүлэхээр санал хүргүүлсэн ТАХ тоо	Төлөвлөсөн төсөвт өртөг	МУ-ын 2024 оны Төсвийн тухай хуульд шинээр хэрэгжихээр батлагдсан ТАХ тоо	Хуулиар батлагдсан төсөвт өртөг	Үүнээс: аймгийн ТЕЗ-ийн саналд үндэслэн баталсан	
						Төсөл арга хэмжээний тоо	Төсөвт өртөг
1	БХБС	6	14,331.7			0	-
2	МУШС			1	1,000.0	0	-
3	ЭХС	2	4,004.5	4	22,785.9	4	22,785.9
4	ХНХС	2	7,187.4	1	2,662.3	1	2,662.3
5	ЗТХС	5	19,404.5	2	22,667.4	1	4,673.1
6	БШУС	3	22,857.1	4	24,722.9	3	23,691.2
7	Соёлын сайд	1	7,122.0	2	13,778.0	1	12,278.0
8	ХХААХҮС	3	5,644.6	1	1,500.0	0	-
	Нийт	22	80,551.8	15	89,116.5	10	66,090.5

(Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2023 оны А/797 албан бичиг, хавсралт,
<https://pimis.publicinvestment.gov.mn/#/nimis/planning/pln/1001>)

Хүснэгтээс харахад: Шинээр хэрэгжүүлэх 22 ТАХ-ний саналыг хүргүүлсэн ба 15 ТАХ Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд батлагдсан байна. Батлагдсан 15 ТАХ-ний 8 буюу 53 хувь нь аймгийн ТЕЗ-ийн саналд үндэслэжээ. Аймгийн ТЕЗ-ийн саналд үндэслээгүй төсөл, арга хэмжээг харьяалах салбарын ТЕЗ-ийн саналаар төлөвлөсөн тул төлөвлөлтэй холбоотой асуудлыг аудитад хамруулаагүй.

А.3. Аймгийн ТЕЗ-ийн саналд үндэслэж шинээр хэрэгжихээр батлагдсан 8 төсөл, арга хэмжээ төлөвлөлтийн шаардлага хангасан.

ТЕЗ-ийн саналд үндэслэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд
батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалт

Хүснэгт №3

(сая төгрөгөөр)

№	ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭР	ТӨСӨВ ӨРТӨГ	ХЭРЭГЖИХ ХУГАЦАА	
1	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Говьсүмбэр, Сүмбэр сум, 5 дугаар сургууль/	12,878.5	2024	2026
2	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал, /Говьсүмбэр, Сүмбэр сум, 1 дүгээр сургууль/	7,811.3	2024	2026
3	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 120 ор /Говьсүмбэр, Сүмбэр сум, 6 дугаар цэцэрлэг/	3,001.4	2024	2025
4	Ахмадын өргөөний барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/	2,662.3	2024	2025

5	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 3.4 км /Говьсүмбэр, Баянтал сум/	4,673.1	2024	2025
6	Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн хэвтээ тэнхлэгийн авто зам, Чойр-Их залаат овооны ар хүртэлх хатуу хучилттай авто замын эхний үе шат /Говьсүмбэр/	17,994.3	2024	2025
7	Усан бассейн бүхий спорт цогцолборын барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/	12,278.0	2024	2026
8	Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтэц, 2 дугаар хэлхээ /Говьсүмбэр, Сүмбэр сум/	11,575.6	2024	2025
НИЙТ		72,874.5		

(Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2023.07.26-ны өдрийн А797 тоот албан бичиг, Сангийн яамны цахим систем <https://pimis.publicinvestment.gov.mn/#/nimis/planning/pln/1001>)

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар Говьсүмбэр аймагт 118,369.5 сая төгрөгийн 22 төсөл, арга хэмжээ батлагдсан. Үүнээс 30,268.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 ТАХ эрх шилжиж хэрэгжсэн байна. Үүнээс 2024 онд шинээр 2 төсөл, арга хэмжээний эрхийг Говьсүмбэр Төсвийн Ерөнхийлөн захирагчид шилжүүлсэн бөгөөд “Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 3.4 км /Говьсүмбэр, Баянтал сум/” ажил нь төлөвлөлтийн шаардлага хангасан бол тоног төхөөрөмж ангилалд батлагдсан “Политехник коллежийн тоног төхөөрөмж /Говьсүмбэр, Сүмбэр сум/” төслийг салбарын ТЕЗ төлөвлөсөн тул аудитад хамрагдаагүй болно.

А.4. Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд Политехник коллежийн тоног төхөөрөмж нэр, зориулалттай батлагдсан боловч төслөөс тавилга эд хогшил, хангамжийн материал худалдан авч зориулалтыг нь өөрчилсөн байна.

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар Говьсүмбэр аймагт хэрэгжихээр баталсан төсөл, арга хэмжээнүүд нь Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцсэн байна. Харин **Политехник коллежийн тоног төхөөрөмж гэсэн зориулалттай** төслөөс тавилга эд хогшил, хангамжийн материал худалдан авч улсын төсвийн хөрөнгө оруулалтын ач холбогдол, үр ашгийг бууруулсан байна.

Политехник коллежийн тоног төхөөрөмж төслөөр
худалдан авсан тавилга, эд хогшлын жагсаалт

Хүснэгт №4

(сая төгрөгөөр)

№	БАГЦ №	ТЕНДЕРИЙН НЭР	ГЭРЭЭНИЙ ДҮН
1	Багц №3	Дотуур байрны эд хогшил, тоног төхөөрөмж - модон ор-61.0 сая, - ширээ-32.1 сая, - сандаал-10.8 сая, - матрас-60.8 сая, - хөнжил-15.5 сая, - хагас автомат угаалгын машин-2.7 сая гэх мэт	217.8

Тухайн батлагдсан хөрөнгө оруулалтаар Политехник коллежийн гол үйл ажиллагааны чиглэл болох уул уурхайн мэргэжилтэн бэлтгэхэд хэрэгцээ шаардлагатай сургалтын тоног төхөөрөмж, уул уурхайн хүнд машин механизмаар хангах боломжтой байсан ч нийт төсөвт өртөг болох 1,031.7 сая төгрөгөөс 268.5 сая төгрөгөөр 1 ширхэг универсал трактор худалдан авсан байна. Тоног төхөөрөмж ангилалд батлагдсан төсвөөс тавилга, эд хогшил худалдан авч төсвийн хөрөнгийг зориулалт бус, үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24², 41 дүгээр 41.2.2³, 41.2.3⁴-т заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.

² 4.1.24. "төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

³ 41.2.2. батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;

⁴ 41.2.3. төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;

Мөн Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд Говьсүмбэр, Дундговь аймагт хэрэгжихээр батлагдсан дараах төслөөс Говьсүмбэр аймагт хөрөнгө хуваарилаагүй байна.

Говьсүмбэр, Дундговь аймагт хэрэгжихээр батлагдсан ТАХ-ний жагсаалт
Хүснэгт №4 (сая төгрөгөөр)

№	Төсөл, арга хэмжээний нэр	ТЕЗ	Төсөвт өртөг	ТЕЗ-аас Говьсүмбэр аймагт хуваарилсан дүн
1	“Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл /Говьсүмбэр, Дундговь/”	ХХААХҮС	1,500.0	0
2	Соёлын салбарын тоног төхөөрөмж /Дундговь, Говьсүмбэр/	ССАЖЗС	1,500.0	206.2
Нийт			3,000.0	206.2

(Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хууль)

Хүснэгтээс харахад 3,000.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төслөөс Говьсүмбэр аймагт зөвхөн 1 төслөөс нь 206.2 сая төгрөгийг хуваарилж, 1 төсөлд огт хөрөнгө хуваарилаагүйгээс орон нутаг улсын төсвийн хөрөнгө оруулалтаас үр өгөөж хүртээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6⁵, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.8.32⁶-т заасантай нийцэхгүй байгаа тул Үндэсний аудитын газарт төсвийг бүсчилсэн байдлаар төлөвлөх, санхүүжүүлэхэд шаардлагатай хууль эрх зүйн зохицуулалтыг хийх саналыг хүргүүлэхээр шийдвэрлэв.

БҮЛЭГ 2

Политехник коллежийн тоног төхөөрөмж нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулаагүй байна.

Б.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах, эрх шилжүүлэх, худалдан авах ажиллагааны журмыг сонгох үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

Тайлант хугацаанд ТЕЗ-ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 5,704.8 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулж 63.8 сая төгрөгийн гэрээний хэмнэлт үүссэн байна.

Худалдан авах ажиллагааны судалгаа
Хүснэгт №5 (сая төгрөгөөр)

Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая.төг/	Эрх шилжүүлсэн шийдвэрийн огноо	Үнэлгээний хороо байгуулсан огноо	Тендерийг анх зарласан огноо	ХАА-нд мөрдөгдсөн журам	Гэрээ байгуулах эрх олгосон огноо	Шалгарсан үнийн дүн	Тендерийн хэмнэлт
Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 3.4км /Говьсүмбэр, Баянтал сум/	4,673.1	ЗГ-н 2023-11-22	2024-01-10	2024-02-01	НТШ	2024-02-26	4,619.2	53.8

⁵ 33.2.6.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, төслийн код, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, анхны төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн/;

⁶ 4.8.32.Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний ангиллын төслийн зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршилыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер шалгаруулалт зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй байх;

Политехник коллежийн тоног төхөөрөмж /Говьсүмбэр, Сүмбэр сум/	1,031.7	ЗГ-н 2023-11-22	2024-04-23	2024-04-23 2024-06-05	НТШ	2024-05-16 2025-06-27	1,021.7	9.9
---	---------	-----------------	------------	--------------------------	-----	--------------------------	---------	-----

(Эх сурвалж: Худалдан авах ажиллагааны газрын Төсвийн Ерөнхийлөн захирагчийн худалдан ажиллагааны тайлан, ЗГ-ын 2023 оны 409 дүгээр тогтоол)

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендер шалгаруулалтын аргыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн сонгосон байна.

Б.2 Политехник коллежийн тоног төхөөрөмж худалдан авах тендер шалгаруулалтын баримт бичгийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн боловсруулаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1⁷-т заасны дагуу тендер шалгаруулалтын баримт бичгийг захиалагч багтах, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1⁸-т заасны дагуу захиалагч техникийн тодорхойлолтод холбогдох норм, стандарт, дүрэм, зааврыг захиалагч тусгах хуулийн зохицуулалттай.

Гэвч Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн сургалтын тоног төхөөрөмж худалдан авах тендер шалгаруулалтын баримт бичгийн багц №1, №2, №3-н техникийн тодорхойлолтод зарим тоног төхөөрөмжийн зайлшгүй шаардлагатай үзүүлэлт, хүчин чадал, мөрдөж буй стандарт, норм, дүрмийн шаардлагыг тусгаагүйгээс хэрэгцээ шаардлагад нийцээгүй, технологийн хоцрогдолд орсон, зах зээлийн үнээс өндөр үнэтэй тоног төхөөрөмж нийлүүлэх нөхцөл боломжийг бий болгосон байна.

Багц №1, №2, №3-н техникийн тодорхойлолтод зайлшгүй шаардлагатай үзүүлэлт, хүчин чадлыг тусгаагүй тоног төхөөрөмжийн жагсаалт

Хүснэгт №6

№	Тоног төхөөрөмжийн нэр	Техникийн тодорхойлолтод тусгаагүй үзүүлэлтүүд	Тайлбар
1	75, 98 инчийн ухаалаг самбар	CPU	CPU-i7 гэж тусгасан боловч хэддүгээр үеийн i7 сру-тэй байх шаардлагыг тодорхой тусгаагүй.
		RAM	RAM (random access memory) буюу түр санах ойн багтаамж, хэддүгээр үеийн ram-тай байх шаардлагыг тусгаагүй.
		GPU	GPU (Graphics Processing Unit) буюу дүрс боловсруулах нэгжийн үзүүлэлтийг тусгаагүй.
		HDD	HDD (Hard Disk Drive) буюу компьютерт заавал байх өгөгдөл хадгалах төхөөрөмжийн төрөл (SSD, HDD, NVMe), хэмжээ (storage) ямар байх шаардлагыг тусгаагүй.
2	Угаалгын машин	Автомат, хагас автомат, хувцас хатаагчтай, уурын угаалгатай, цахилгаан зарцуулалт, моторын хүч, угаалгын төрөл гэх мэт	Автомат, эсвэл хагас автомат эсэхийг тодорхойлоогүй. Уурын угаалга, хувцас хатаагч, моторын хүч зэрэг гол үзүүлэлт техникийн шаардлагыг тусгаагүйгээс хэт өндөр үнэтэй хагас автомат машин нийлүүлсэн.
3	Сандал ширээний ком	Ширээ, сандлын стандарт хэмжээ, эрүүл мэндэд харшлахгүй байх материал гэх мэт	Ширээ, сандлын биет хэмжээ, хийсэн материал, эрүүл ахуйн стандарт шаардлагыг тусгаагүй.
4	Универсаль трактор	Тэнхлэг хоорондын зай, оврын хэмжээ, дугуйн хэмжээ, кабин дотор АС болон халаалтын систем	Тэнхлэг хоорондын зай, оврын хэмжээ, дугуйн хэмжээ, кабин дотор АС болон халаалт гэх мэт зайлшгүй байх техникийн зарим шаардлагын талаар тусгаагүй.

(Эх сурвалж: Политехник коллежийн тендер шалгаруулалтын баримт бичиг-Техникийн тодорхойлолт)

⁷ 11.1.Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална.

⁸ 12.1.Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана.

Политехник коллежийн тоног төхөөрөмж худалдан авах тендер шалгаруулалтын баримт бичигт *Ухаалаг самбарын техникийн тодорхойлолтод процессорын хүчин чадалтай холбоотой гол үзүүлэлтийг тодорхой тусгаагүйгээс* 38.0 сая төгрөгөөр нийлүүлсэн 3 ш ухаалаг самбар хүчин чадал муу, технологийн хувьд хоцрогдолд орсон (Cpu i7-4700, Ram DDR-3) үзүүлэлттэй тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.18⁹, 11 дүгээр зүйлийн 11.2¹⁰, 12 дугаар зүйлийн 12.1¹¹, 27 дугаар зүйлийн 27.3¹² гэж заасныг тус тус зөрчсөн тул алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Б.3 Үнэлгээний хороо тендер шалгаруулалтын баримт бичгийг бодитоор үнэлээгүйгээс шаардлага хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Политехник коллежийн тоног төхөөрөмж нийлүүлэгчийг сонгон шалгахуулах үнэлгээ хороо нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан дараах шаардлагыг утга агуулгын хувьд оновчтой тодорхойлоогүйгээс хоёрдмол утга санаа үүссэн байна. Үүнд:

1. ТШЗ 18.1-т “Гүйцэтгэх хүний нөөцийн нотлох баримт ирүүлэх”-г шаардсан бөгөөд *“Дээрх ажилчид тухайн байгууллагын үндсэн ажилтан байх шаардлагагүй бөгөөд нийгмийн даатгалын шимтгэлийг сүүлийн 3 сар тендерт оролцогч тасралтгүй төлсөн лавлагааг “Е Mongolia”-оос татаж, сканердаж тендерт ирүүлнэ.”* гэж заасны дагуу тендерт оролцогч байгууллагын үндсэн болон гэрээт ажиллагсдын нэр дээр тухайн компаниас шимтгэл төлөлт бүртгэгдээгүй байсан. Мөн Жаргалант транспортны экспедитор ХХК-ний ирүүлсэн тендерийн баримт бичигт 2024.05.14-ний өдрийн ажилд томилсон тушаалаар ажиллагсдыг тус төсөлд ажиллах нөхцөлтэйгээр томилох хуулбарыг ирүүлсэн байна. Үүнээс үзвэл оролцогч тендер шалгаруулалтын баримт бичигт заасан дээрх шаардлагад нийцээгүй гэж дүгнэлт хийж болохоор байна.
2. ТШЗ 18.1-т Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: *“Шаардлагатай” Багц тус бүр дээр 2021, 2022, 2023 онд гүйцэтгэсэн ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний талаар V бүлгийн МАЯГТ 3, МАЯГТ 5-ын дагуу бэлтгэж ирүүлнэ.* гэж заасан боловч багц 1-т “Жаргалант транспортны экспидитор” ХХК маягт 3-г бэлтгэж ирүүлээгүй байхад сонгон шалгаруулсан байна. Энэ нь ижил төрлийн тендер шалгаруулалтын баримт бичигт гарсан гомдолд Сангийн яамны 2024.04.15-ны өдрийн 03/2631 тоот албан бичгээр өгсөн хариуг үндэслэсэн үнэлгээ хийжээ.
3. Үнийн саналд зах зээлийн үнээс хэт өндөр буюу 2.7 сая төгрөгөөр хагас автомат 1 ширхэг угаалгын машин нийлүүлэх санал ирүүлсэн байхад захиалагч болон үнэлгээний хороо арифметик алдаа гарсан эсэх талаар гүйцэтгэгч байгууллагаас тодруулга аваагүй хуульд заасан чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Тендер шалгаруулалтын баримт бичгийн шалгуурт ойлгомжгүй, хоёрдмол утга санаа тусгаснаар шаардлага хангахгүй оролцогч шалгарах нөхцөл бүрдэх, худалдан авах ажиллагааны зарчим алдагдах сөрөг үр дагавартай байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1¹³, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1¹⁴, 11 дүгээр

⁹ 4.1.18.“техникийн тодорхойлолт” гэж худалдан авах бараа, ажил, үйлчилгээний техникийн үзүүлэлт, үйлдвэрлэл, үйл ажиллагааны арга, технологи, түүнд тавигдах технологийн шаардлага, даалгаврыг тодорхойлсон бүрдүүлбэрийг

¹⁰ 11.2.Оролцогчийг тендер бэлтгэж ирүүлэхэд шаардагдах мэдээлэл, оролцогчид тавих шаардлага, заавар, хамгийн сайн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, тендерийн жишиг маягтыг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана.

¹¹ 12.1.Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана.

¹² 27.3.Үнэлж байгаа тендерийн үнэд арифметик алдаа байвал захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар залруулж, энэ тухай оролцогчид мэдэгдэж, хүлээн зөвшөөрөх эсэх талаар бичгээр хариу ирүүлэхийг шаардана.

¹³ 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

¹⁴ 5.1.Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.

зүйлийн 11.2¹⁵, 17 дугаар зүйлийн 17.2.2¹⁶, 17 дугаар зүйлийн 17.4¹⁷, 28 дугаар зүйлийн 28.1.3¹⁸-т заасантай нийцэхгүй байх тул зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг аймгийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэхээр шийдвэрлэв.

Мөн үнийн дүнд дүйцэхээргүй, зах зээлийн үнээс хэт өндөр үнэтэй хагас автомат угаалгын машины үнийн зөрүү 2.0 сая төгрөгийг тендер шалгаруулалт зохион байгуулсан үнэлгээний хороо, техникийн тодорхойлолтын дагуу барааг хүлээн аваагүй ажлын хэсгийн дарга, гишүүдээр төлүүлж, орон нутгийн орлогод төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

Цаашид захиалагч байгууллага үнэлгээний хороонд үнэлгээ хийхэд шаардлагатай баримт материал, зах зээлийн үнийн болон жишиг үнийн судалгааг хүргүүлдэг байх, худалдан авах ажиллагааны үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

БҮЛЭГ 3

Зарим ажлын гүйцэтгэлийг бодитоор баталгаажуулаагүй, он дамжин хэрэгжиж буй 3 төсөл хугацаандаа хэрэгжээгүй, ашиглалтад хүлээн авсан Шивээговь сумын цэцэрлэгийн барилгыг хөрөнгийн бүртгэлд бүртгээгүй, Политехник коллежид нийлүүлсэн сургалтын тоног төхөөрөмж ашиглалтын шаардлага хангахгүй байна.

В.1 Зарим ажлын гүйцэтгэлийг бодитоор баталгаажуулаагүй байна.

Говьсүмбэр аймагт эрх шилжин хэрэгжиж буй 30,268.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9,854.5 сая төгрөгийн санхүүжих дүн бүхий 7 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 10,441.2 сая төгрөгийг эрх шилжсэн хөрөнгө оруулалт данснаас олгосон байна.

Санхүүжилтийн судалгаа

Хүснэгт №7

(сая төгрөгөөр)

Эрх шилжсэн ТАХ-ний 2024 онд санхүүжих дүн	Олгосон санхүүжилт	Зөрүү	Үүнээс: ТЕЗ-аас зохицуулалт хийж олгосон	Төсөвт буцаан татагдсан	Алданги тооцож суутгасан	Олгосон санхүүжилтээс барьцаа дансанд шилжүүлсэн
9,854.5	10,441.2	(586.7)	633.6	(44.2)	(2.7)	3,536.6

(Эх сурвалж: Хөрөнгө оруулалтын баримт, дансны хуулга, аудитын судалгаа)

Хүснэгтийн тайлбар: БШУС-ын багцад батлагдсан “Цэцэрлэгийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Шивээговь сум, 1 дүгээр баг/” төсөл нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн (2006) 40 дүгээр зүйлийн 40.6¹⁹, Засгийн газрын 2022 оны 72 дугаар тогтоолын дагуу бараа материалын үнийн өсөлтийн зөрүүгээр нэмэлт гэрээ байгуулж төсөвт өртөг 633.6 сая төгрөгөөр нэмэгдсэн мөн хугацаанаасаа өмнө ашиглалтад орсон тул ТЕЗ-ийн багцад зохицуулалт хийж 633.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Сүмбэр сум/-ийн 44.2 сая төгрөг ажил зогссон тул төсөвт буцаан татагдсан, Политехник коллежийн багц №4-өөс 2.5 сая төгрөгийн алданги тооцсон тул дутуу санхүүжилт авсан байна.

¹⁵ 11.2.Оролцогчийг тендер бэлтгэж ирүүлэхэд шаардагдах мэдээлэл, оролцогчид тавих шаардлага, заавар, хамгийн сайн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, тендерийн жишиг маягтыг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана.

¹⁶ 17.2.2.бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх тендер шалгаруулалтын хувьд сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд нийлүүлсэн бараа, үзүүлсэн үйлчилгээний жагсаалт, тэдгээрээс ижил төстэй бараа, үйлчилгээний өртөг, хугацаа, байршил, гэрээний үүргийг гүйцэтгэсэн болохыг нотлох баримт;

¹⁷ 17.4.Оролцогч захиалагчийн тогтоосон техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.

¹⁸ 28.1.3 шаардлагад нийцээгүй тендер ирүүлсэн оролцогчийн тендерээс татгалзах.

¹⁹ 40.6.Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих ажил гүйцэтгэх төсөл, арга хэмжээний ажлын тоо хэмжээ өөрчлөгдсөнтэй холбоотойгоор төсөвт өртгийг хуулиар нэмэгдүүлэн баталсан бол захиалагч магадлалын дүгнэлтэд үндэслэн тухайн ажлын гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний үнэ, ажлын тоо хэмжээг нэмэгдүүлэн баталсан төсөвт өртөгт багтаан нэг удаа өөрчилж болно.

Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 6.9 км /Говьсүмбэр, Шивээговь сум/ төслийн санхүүжилт 3,086.7 сая, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/ төслийн санхүүжилт 449.9 сая, нийт 3,536.6 сая төгрөгийн санхүүжилтийг барьцаа дансанд төвлөрүүлсэн бөгөөд дараах шалтгаантай байна.

1. Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 6.9 км /Говьсүмбэр, Шивээговь сум/ төсөл-барьцаа данснаас олгосон 916.3 сая төгрөгийн санхүүжилтийг бодит гүйцэтгэлтэй уялдуулж олгоогүй байна. Иймд 2024 онд дутуу ажлаа гүйцэтгэж нэмж санхүүжилт аваагүй. Тайлант оны санхүүжилт 3,086.7 сая төгрөгийг барьцаа дансанд шилжүүлсэн.
2. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/ төслийг гүйцэтгэгч компани гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүй тул санхүүжилтийг барьцаа дансанд байршуулсан.

Цаашид ажлын гүйцэтгэлийг бодитоор баталгаажуулах, санхүүжилтийг хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн олгох зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

В.2 Он дамжин хэрэгжиж буй 3 төсөл, арга хэмжээ гэрээний хугацаандаа хэрэгжээгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна.

Эрх шилжин хэрэгжиж буй 7 төсөл, арга хэмжээнээс хэрэгжиж дууссан 2, хугацаа болоогүй он дамжин хэрэгжих 2, хугацаандаа хэрэгжээгүй 3 төсөл, арга хэмжээ байна.

Төлөвлөсөн хугацаандаа хэрэгжсэн ТАХ:

1. Цэцэрлэгийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Шивээговь сум, 1 дүгээр баг/,
2. Политехник коллежийн тоног төхөөрөмж /Говьсүмбэр, Сүмбэр сум/ 2 төслийг төлөвлөсөн хугацаанд нь хэрэгжүүлж гэрээг дүгнэсэн байна.

Төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй ТАХ:

Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Сүмбэр сум/ - 2021 оноос хойш зогсонги байдалд орж ажил удааширсан гэрээний хугацаа дууссан ажлын гүйцэтгэл 85 хувь:

Зураг төсвийг Гандирс од ХХК 2015 онд боловсруулж, барилгын хөгжлийн төвөөр магадлал хийлгэн төсөвт өртгийг 1,619.2 сая төгрөгөөр баталгаажуулсан бөгөөд 2019 онд улсын төсөвт 1,619.2 сая төгрөгөөр батлагджээ.

Аймгийн ТЕЗ-аас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Тус барилгын ажил дараах нөхцөл шалтгааны улмаас зогссон байна. Үүнд:

1. Барилгын төсөвт өртөгт цалин хөлсний үнэлгээг Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2009 оны 263 дугаар тушаалаар батлагдсан тарифт цалингаар тооцсоныг шинэчлэх
2. Бараа материалын үнийн өсөлт үүссэн тул тухайн төсөвт багтааж ажил гүйцэтгэх боломжгүй болсон. Хөөсөнцөр фасадыг металл фасадаар солих, тохижилтын ажлыг нэмж тусгах, зураг төсөл, төсөвт өртөгт өөрчлөлт оруулан магадлалаар баталгаажуулан улсын төсөвт тусгуулах

Аймгийн засаг даргын 2023.09.20-ны өдрийн А/292 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг гүйцэтгэгч Түмэн-Алт ХХК-нийн удирдлага, менежертэй 2023.10.04-ний өдөр уулзалт хийхэд гүйцэтгэгч талаас барилгын хөгжлийн төвд дахин магадлал хийлгэх албан бичиг хүргүүлэх, эхний ээлжинд орон нутгийн төсвөөс 100.0 сая төгрөг олгох саналыг хүргүүлсэн бөгөөд орон нутгаас уг төсөлд хөрөнгө хуваарилах боломжгүй тул уг санал дэмжигдээгүй байна. Мөн аймгийн 2025.3.17-ны өдрийн А/264 тоот албан бичгээр Боловсролын сайдад албан бичиг хүргүүлж цэцэрлэгийн барилгын төсөвт өртгийн 1,027.0 сая төгрөгөөр нэмэгдсэнийг барилгын хөгжлийн төвөөр хянуулж, Үндэсний аудитын газарт хүргүүлсэн байна.

Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/ - 2022 оноос хойш зогсонги байдалд орж ажил удааширсан гэрээний хугацаа дууссан ажлын гүйцэтгэл-65 хувь:

Зураг төсвийг Нарлаг хөхий ХХК 2018 онд боловсруулж, барилгын хөгжлийн төвөөр магадлал хийлгэн төсөвт өртгийг 2,435.7 сая төгрөгөөр баталгаажуулсан бөгөөд 2018 онд улсын төсөвт 2,200.0 сая, 2024 оны төсөвт 2,408.1 сая төгрөгөөр батлагджээ. Уг ажилд 258.1 сая төгрөгийн бараа материалын үнийн өсөлтийн зөрүүг улсын төсвөөс олгосон бөгөөд гүйцэтгэгч байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалан ажил зогссон байна.

Аймгийн ТЕЗ-аас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Аймгийн засаг даргын 2024.03.25-ны өдрийн Б/331 тоот албан бичгээр захиалагч буюу аймгийн ЗДТГ-т Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилгын ажлын гэрээг дүгнэх, шаардлагатай арга хэмжээг авах албан бичгийг хүргүүлсэн байна. Мөн аймгийн Засаг даргын 2025.03.13-ны өдрийн А/103 дугаартай захирамжийн дагуу байгуулагдсан ажлын хэсэг 2025.03.18-ны өдөр барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилгад гаргуулсан байна. Уг дүгнэлтээр барилгын үндсэн хийц бүтээц шаардлага хангаж байгаа тул үргэлжлүүлэх боломжтой гэж дүгнэжээ. Мөн 2025.03.19-ний өдөр гүйцэтгэгч Хан аттрибут ХХК-ний захиралтай уулзалт хийж дараах шийдэлд хүрсэн байна.

- Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилгын ажил хийгдсэн болон гүйцэтгэлээс илүү олгосон ажлын тоо хэмжээг Хан аттрибут ХХК, захиалагчийн хяналтын байгууллагатай хамтарч гаргах, гүйцэтгэлээс дутуу буюу чанарын шаардлага ханаагүй ажлыг гүйцээж хийх, хийгдээгүй үлдсэн ажилд төсөв хийлгэх /илүү олгосон санхүүжилтийн талаар 2022 оны аудитын тайланд бичигдэж албан шаардлага өгсөн/

Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 6.9 км /Говьсүмбэр, Шивээговь сум/ ажлын гүйцэтгэл-27 хувь

- Зураг төсвийг Арвай нутгийн зам ХХК 2020 онд боловсруулан, магадлал хийлгэж төсөвт өртгийг 5,355.6 сая төгрөгөөр баталгаажуулсан бөгөөд 2022 онд улсын төсөвт 5,355.6 сая төгрөгөөр батлагджээ. Уг төслийн гэрээний хугацаа дууссан боловч сунгалт хийгээгүй байна.

Аймгийн ТЕЗ-аас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Автозамын зургийн чиглэлд өөрчлөлт орсонтой холбоотойгоор (их хэмжээний үерийн улмаас) ажлын тоо хэмжээ нэмэгдэж зураг төсөвт дахин магадлал хийлгэх шаардлага үүссэн. Гүйцэтгэгч байгууллага болох Даблю Экс Пи ХХК-иас зураг төсвийг шинэчлэх саналыг аймгийн ЗДТГ-т хүргүүлэн 2023.10.27-ны өдөр талууд хуралдаж дээрх саналыг дэмжсэн байна. 2024 онд зургийн өөрчлөлттэй холбоотойгоор гүйцэтгэл гараагүй, санхүүжилт авах боломжгүй нөхцөл үүссэн гэж гүйцэтгэгч талаас үзэж 2025.02.27-ны өдрийн 04/39 албан бичгээр гэрээ цуцлах саналыг захиалагч байгууллагад хүргүүлсэн байна. Аймгийн Засаг даргын 2025.03.13-ны өдрийн А/103 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2025.03.17-ны өдөр гүйцэтгэгч Даблю экс пи ХХК-ний захиралтай уулзалт хийж дараах шийдэлд хүрсэн байна.

1. Хяналт хэрэгжүүлэгч байгууллага анхны тоо хэмжээг одоогийн гүйцэтгэлтэй харьцуулан гүйцэтгэгч байгууллагатай тулгаж баталгаажуулах
2. Нэмэлт хийсэн ажил үлдэгдэл ажлын тоо хэмжээг гүйцэтгэгч тал зураг төсөв зохиогч байгууллагууд баталгаажуулах
3. Зураг төсөв зохиогч Арвайн нутгийн зам ХХК нь үлдсэн ажлын тоо хэмжээг гаргаж зураг төсөвт холбогдох өөрчлөлтийг хийж Зам тээврийн хөгжлийн төвөөр магадлал хийлгэх
4. Захиалагч тал гэрээний сунгалтыг хийх
5. Гүйцэтгэгч байгууллага 2025 оны ажил гүйцэтгэх графикийг 2025.04.05-ны дотор ирүүлэх

Үлдэгдэл ажлын тоо хэмжээ, зураг төсвийг 2025.04.15-ны өдөр Зам тээврийн хөгжлийн төвөөр магадлал хийлгэсэн байна.

Цаашид Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3²⁰-т заасны дагуу төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг сайжруулах, үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.

В.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн зарим тоног төхөөрөмж техникийн тодорхойлолтод нийцээгүй, ажил хүлээн авах комисс, ашиглагч байгууллага шаардлага хангаагүй тоног төхөөрөмжийг хүлээн авсан байна.

Цэцэрлэгийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Шивээговь сум, 1 дүгээр баг/ төслийг хугацаанаас өмнө нь батлагдсан зураг төсвийн дагуу гүйцэтгүүлж, хүлээн авсан байна.

Политехник коллежийн тоног төхөөрөмж /Говьсүмбэр, Сүмбэр сум/ төслийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

1. Багц № 1 Аймгийн ЗДТГ-ын даргын 2024.09.19-ний А/56-р тушаалаар байгуулсан 5 гишүүнтэй ажлын хэсэг
2. Багц № 2: Аймгийн ЗДТГ-ын даргын 2024.10.08-ны А/69-р тушаалаар байгуулсан 5 гишүүнтэй ажлын хэсэг
3. Багц № 3 Аймгийн ЗДТГ-ын даргын 2024.09.19-ний А/56-р тушаалаар байгуулсан 5 гишүүнтэй ажлын хэсэг
4. Багц № 4: Аймгийн ЗДТГ-ын даргын 2024.09.03-ны А/53-р тушаалаар байгуулсан 5 гишүүнтэй ажлын хэсэг

Ажлын хэсэг нийлүүлсэн тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолтод заасан үзүүлэлттэй тулган хүлээж аваагүй, нийлүүлэгдсэн хөрөнгө хүний биед сөрөг нөлөө үзүүлэхгүй материалаар хийгдсэн эсэхийг нотолсон баримт бичгийг тулган баталгаажуулаагүй, хөрөнгийн бүрэн бүтэн байдал, тээвэрлэлтийн явцад үүссэн эвдрэл гэмтлийг шалгаж хүлээн аваагүй, зөвхөн тоо ширхгээр хүлээн авч хариуцлагагүй хандсан байна. Тухайлбал:

1. 98.0 сая төгрөгийн 75 инчийн 15ш ухаалаг самбарын (CPU нь 2023 он буюу тухайн жилийн сүүлийн хувилбараар нийлүүлнэ гэж заасан) үзүүлэлт техникийн тодорхойлолтод нийцээгүй (i7-4700 CPU, DDR3 8Gb ram-тайг нийлүүлсэн.)
2. 7.4 сая төгрөгийн 2-р хоолны тогоо 80л багтаамжтай (1375*905*850) байхаар тусгасан ч 50л багтаамжтай (800*900*930) тогоо нийлүүлсэн.
3. 1.2 сая төгрөгийн хөргүүр тээвэрлэлтийн явцад эвдэрсэн байсан ч комисс хөрөнгийг буцаагаагүй, эвдэрхий хөрөнгө хүлээн авсан. /Ашиглах боломжгүй хагарч битүүмж алдагдсан./
4. 46.5 сая төгрөгийн Универсал тракторын цас түрэгч нь техникийн тодорхойлолтод заасантай нийцээгүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4.2²¹, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.8.32²² Политехник коллежийн тоног төхөөрөмж нийлүүлэх тендер шалгаруулалтын баримт бичгийн багц 1-ийн 2, багц 2-ын 2, багц 4-ийн 1, 5-т заасан техникийн тодорхойлолттой нийцээгүй байна.

Тоног төхөөрөмж хүлээн авах ажлын хэсэгт техникийн тодорхойлолт боловсруулж хянасан, үнэлгээний хороонд ажилласан албан хаагчдыг томилж байгаа нь ашиг сонирхлын зөрчилтэй байдал

²⁰ өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;

²¹ 26.4.2.санал болгосон бараа, ажил, үйлчилгээ техникийн тодорхойлолтод нийцсэн байх;

²² 4.8.32.Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний ангиллын төслийн зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер шалгаруулалт зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй байх;

үүсэх эрсдэлтэй тул цаашид анхаарч ажиллах, мөн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл арга хэмжээг хүлээн авах ажлын хэсэгт ашиглагч байгууллагаас шаардлага хангасан мэргэжлийн хүнийг томилж оруулах, ажлын хэсэгт томилогдсон алба хаагчдын хариуцлагыг сайжруулах шаардлагатай байна.

Техникийн тодорхойлолтод нийцээгүй тоног төхөөрөмж хүлээн авсан зөрчлийг арилгах албан шаардлагыг ашиглагч байгууллага, ажил хүлээн авсан ажлын хэсэгт хүргүүлж, ажилдаа хариуцлагагүй хандсан ажил хүлээн авах комиссын албан хаагчдад хариуцлага тооцуулах саналыг аймгийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.

Мөн Соёлын сайдын багцад батлагдсан “Соёлын салбарын тоног төхөөрөмж /Дундговь, Говьсүмбэр/” 1,500.0 сая төгрөгийн төслөөс Говьсүмбэр аймгийн Боржигин чуулга, 3 сумын соёлын төв, Нийтийн номын сан, Боржигин өв музейд 206.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн боловч нийлүүлсэн тоног төхөөрөмжүүд нь ашиглагч байгууллагуудаас өгсөн санал болон техникийн тодорхойлолтоос зөрүүтэй. Гүйцэтгэгч компани хөрөнгийг албан ёсоор хүлээлгэн өгөөгүй тул техникийн үзүүлэлтийн дагуу хүлээлцсэн акт байхгүй, ачаа тээврийн компаниар ашиглагч байгууллагуудад хүргүүлсэн нөхцөл байдалтай байна. Иймд дээрх асуудлыг Үндэсний аудитын газарт уламжлахаар шийдвэрлэв.

В.4 Политехник коллежид нийлүүлсэн тоног төхөөрөмжийн дүнг 4.6 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн, универсал трактор болон зарим тоног төхөөрөмжүүд ашиглалтын шаардлага хангахгүй байгаагаас зориулалтын дагуу ашиглаагүй байна.

Говьсүмбэр аймагт хэрэгжсэн улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон Цэцэрлэгийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Шивээговь сум, 1 дүгээр баг/ төслийг улсын комиссын 2024.09.19-ний өдрийн 08 дугаартай актаар ашиглалтад хүлээн авсан боловч эрх бүхий байгууллагын шийдвэр албажиж гаргаагүйгээс хөрөнгийн бүртгэл тайлант ондоо багтаж хийгдээгүй, ашиглагч байгууллага буюу Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025.03.20-ны өдрийн 128 дугаар тогтоолыг үндэслэн он дамжуулан 2025.03.31-нд бүртгэсэн байна.

Зураг №1



Цэцэрлэгийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Шивээговь сум, 1 дүгээр баг/

Политехник коллежийн тоног төхөөрөмж /Говьсүмбэр, Сүмбэр сум/ төслөөс нийлүүлсэн тоног төхөөрөмжийг бүртгэл тайланд 4.6 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн байна. Үүнд: 0.95 сая төгрөгийн камерын бичигчийг 0.095 сая, 4.2 сая төгрөгийн сүлжээ салаалагчийг 0.42 сая төгрөгөөр тус тус бүртгэсэн байна.

Мөн ашиглалтад хүлээн авсан зарим тоног төхөөрөмж ашиглалтгүй, ашиглалтын шаардлага хангаагүй байна.

Зураг №2



268.5 сая төгрөгийн универсал тракторын үйлдвэрийн чангалгаа хийгээгүй, ажил болон сургалтын үйл ажиллагаанд бэлэн бус учраас ашиглалтгүй.

Зураг №3



1.2 сая төгрөгийн хөргүүр тээвэрлэлтийн явцад эвдэрч гэмтсэн тул ашиглалтын шаардлага хангахгүй.

Зураг №4



4.2 сая төгрөгийн хурлын заалны микрофон ашиглалтгүй.

Зураг №5



4.2 сая төгрөгийн 48 порттой сүлжээ салаалагч ашиглалтгүй.

Ашиглалтад хүлээн авсан дээрх хөрөнгүүдийг зориулалтын дагуу ашиглаагүй, бүртгэл тайланд дутуу бүртгэсэн нь хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2²³, Засгийн газрын 2023 оны 278-р тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.8.30²⁴, 5.5.1²⁵ - т заасныг тус тус зөрчсөн тул хөрөнгийг өмчлөлд бүрэн бүртгэх, ашиглалтын шаардлага хангахгүй байгаа хөрөнгийг баталгааны хугацаанд хэвийн байдалд оруулан зориулалтын дагуу ашиглах албан шаардлагыг захиалагч, ашиглагч байгууллагад хүргүүлэхээр шийдвэрлэв.

Аудитаар нийт 689.1 сая төгрөгийн 9 зөрчил илрүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж, 2.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, хариуцлага тооцуулах 151.9 сая төгрөгийн 1 албан шаардлага, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 535.2 сая төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

²³ 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;

²⁴ 4.8.30.Эцсийн буюу бүрэн санхүүжилтийг авахад тухайн төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллага нь бүртгэлд тусгасныг нотлох баримт үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд хавсаргах бөгөөд цахим системд баталгаажуулсан байна;

²⁵ 5.5.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу төрийн болон орон нутгийн өмч байх буюу төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг байнгын ашиглалтад хүлээн авсан, тоног төхөөрөмж хүлээн авсан акт болон зураг төсөл, ТЭЗҮ-г захиалагч хүлээн авсны дараа төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлнэ;

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Говьсүмбэр аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт өмнөх оноос сайжирсан, хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн хэдий ч зөрчлийн хэмжээ буурахгүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр дүн, үр ашигтай байдалд сөргөөр нөлөөлж байна.

Бүлэг-1

Говьсүмбэр аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг хууль, журамд нийцүүлэн төлөвлөсөн байна.

1. Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд Говьсүмбэр аймагт хэрэгжихээр батлагдсан 22 төсөл, арга хэмжээний 16 буюу 72.7 хувь нь улсын жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй нийцсэн байна.
2. Говьсүмбэр аймгийн ТЕЗ-ийн саналаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээг цахим системээр аргачлалын дагуу үнэлж эрэмбэлэн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцсон байна.
3. Аймгийн ТЕЗ-ийн саналд үндэслэж шинээр хэрэгжихээр батлагдсан 8 төсөл, арга хэмжээ төлөвлөлтийн шаардлага хангасан.
4. Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд Политехник коллежийн тоног төхөөрөмж нэр, зориулалттай батлагдсан төслөөс тавилга эд хогшил, хангамжийн материал худалдан авч зориулалтыг нь өөрчилсөн байна.

Бүлэг-2

Политехник коллежийн тоног төхөөрөмж нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулаагүй байна.

1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах, эрх шилжүүлэх, худалдан авах ажиллагааны журмыг сонгох үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.
2. Политехник коллежийн тоног төхөөрөмж худалдан авах тендер шалгаруулалтын баримт бичгийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн боловсруулаагүй байна.
3. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтын баримт бичгийг бодитоор үнэлээгүйгээс шаардлага хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Бүлэг-3

Зарим ажлын гүйцэтгэлийг бодитоор баталгаажуулаагүй, он дамжин хэрэгжиж буй 3 төсөл хугацаандаа хэрэгжээгүй, ашиглалтад хүлээн авсан Шивээговь сумын цэцэрлэгийн барилгыг хөрөнгийн бүртгэлд бүртгээгүй, Политехник коллежид нийлүүлсэн сургалтын тоног төхөөрөмж ашиглалтын шаардлага хангахгүй байна.

1. Зарим ажлын гүйцэтгэлийг бодитоор баталгаажуулаагүй байна.
2. Он дамжин хэрэгжиж буй 3 төсөл гэрээний хугацаандаа хэрэгжээгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна.
3. Политехник коллежид нийлүүлсэн зарим тоног төхөөрөмж техникийн тодорхойлолтод нийцээгүй, захилагч, ашиглагч байгууллаг, хүлээн авах комисс шаардлага хангаагүй тоног төхөөрөмжийг хүлээн авсан байна.

4. Политехник коллежид нийлүүлсэн тоног төхөөрөмжийн дүнг 4.6 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн, универсал трактор болон зарим тоног төхөөрөмжүүд ашиглалтын шаардлага хангахгүй байгаагаас зориулалтын дагуу ашиглаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Аймгийн Засаг даргад:

1. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний явц, гүйцэтгэлд дотоод хяналт хэрэгжүүлэх, санхүүжилтийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулж олгох
2. Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон ажил болон хөрөнгийг хүлээн авах ажлын хэсгийг томилохдоо ашиглагч байгууллагын төлөөллийг тухайн ажил болон хөрөнгийг хүлээн авах ач холбогдол бүхий мэргэжлийн хүнийг томилж байх, ажлын хэсгийг техникийн тодорхойлолтын дагуу ажил болон хөрөнгийг хянаж хүлээн авдаг байх тогтолцоог хэвшүүлж, ажлын хэсгийг дарга, гишүүдийн хариуцлагыг дээшлүүлэх
3. Захиалагчаас үнэлгээний хороонд үнэлгээ хийхэд шаардлагатай баримт материал, техникийн тодорхойлолтын хамт зах зээлийн үнийн болон жишиг үнийн судалгааг хүргүүлдэг байх, худалдан авах ажиллагааны үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж ажиллах

Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газарт:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлж буй хөрөнгийг ажлын даалгавар, техникийн тодорхойлолттой тулгаж хүлээн авах, хүлээн авсан тоног төхөөрөмжийн ашиглалтын байдалд дотоод хяналт хэрэгжүүлэх

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах саналыг Үндэсний аудитын газарт уламжлахаар шийдвэрлэв.

1. Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд “Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл /Говьсүмбэр, Дундговь/”-1,500.0 сая төгрөгөөр хэрэгжсэн төслөөс Говьсүмбэр аймаг хуваарилаагүй байна. Үүнд төсвийг бүсчилсэн байдлаар төлөвлөх хууль эрх зүйн орчин бүрдээгүй нь тодорхой хэмжээнд нөлөөлж байна гэж үзсэн тул төрөөс баримталж буй Бүсчилсэн хөгжлийн бодлоготой нийцүүлэн төсвийг бүсчилсэн байдлаар төлөвлөх болон батлах, гүйцэтгэлийг хянах, тайлагнах талаар хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох саналтай байна.
2. Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд “Соёлын салбарын тоног төхөөрөмж /Дундговь, Говьсүмбэр/” (эрх шилжээгүй)-1,500.0 сая төгрөгөөр хэрэгжсэн төслөөс Говьсүмбэр аймагт 206.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж хуваарилсан байна. Нийлүүлсэн төхөөрөмжүүд нь ашиглагч байгууллагуудаас өгсөн санал болон техникийн тодорхойлолтоос зөрүүтэй. Гүйцэтгэгч компани албан ёсоор хүлээлгэн өгөөгүй тул хүлээлцсэн акт байхгүй, ачаа тээврийн компаниар ашиглагч байгууллагуудад хүргүүлсэн зэрэг хариуцлагагүй асуудал илэрсэн. Иймд нэгтгэсэн тайланд хамаарах дээрх асуудлыг анхаарч, салбарын ТЕЗ-д зөвлөмж хүргүүлэх саналтай байна.

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Найрамдал хотхон, 3 дугаар баг,
Сүмбэр сум, Говьсүмбэр аймаг, 42015
Утас/Факс: (976) 7054 3118,
Цахим шуудан: zdtg.gsa@gmail.com,
Цахим хуудас: www.govisumber.gov.mn

2025.04.21 № 01/407
танай 2025.04.18-ны № 752 -т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын
ажлуудад хийсэн төрийн аудитын шалгалтын тайлантай
танилцлаа.

Уг тайланд саналгүй болно.

ДАРГА



Д.СОДНОМ

Ахлах аудитор
Б. Дарханбаатар
Тайланг санал
тусганы дагал-
тагтнуулах
[Signature]

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Найрамдал хотхон, 3 дугаар баг,
Сүмбэр сум, Говьсүмбэр аймаг, 42015
Утас/Факс: (976) 7054 3118,
Цахим шуудан: zdtg.gsa@gmail.com,
Цахим хуудас: www.govisumber.gov.mn

2025.04.21 № 01/407
танай 2025.04.18-ны № 752 -т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын
ажлуудад хийсэн төрийн аудитын шалгалтын тайлантай
танилцлаа.

Уг тайланд саналгүй болно.

ДАРГА



Д.СОДНОМ

Ахлах аудитор
Б.Дарханбаатар
Тайланг саналыг
тусган багас-
гагцуулах
М.С.Д.

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Шалгагдагч байгууллагуудаас тайлангийн төсөлтэй холбоотой санал ирээгүй тул Дарга, Тэргүүлэх аудиторын тушаалаар тайланг эцэслэн баталгаажуулав.